



МОНГОЛ УЛСЫН  
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН  
ТУШААЛ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/111

Улаанбаатар хот

Бэлгэ тэмдгийн загвар, хэрэглэх журам  
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 485 дугаар тогтоол, 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-ын 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн бэлгэ тэмдгийн загвар”-ыг нэгдүгээр, “Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн бэлгэ тэмдгийг хэрэглэх журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Бэлгэ тэмдгийн загварыг Оюуны өмчийн газарт бүртгүүлж, Зохиогчийн эрхийн гэрчилгээ авахыг Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн (хурандаа Д.Содномцог)-д хариуцуулсугай.

3. Бэлгэ тэмдгийг хэрэглэх журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн (хурандаа Д.Содномцог)-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (хурандаа Н.Пүрэвдорж)-т даалгасугай.

САЙД



Г.САЙХАНБАЯР


1324100251

Батлан хамгаалахын сайдын 2024 оны  
13 дугаар сарын 29-ны өдрийн  
1111 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

БАТЛАН ХАМГААЛАХЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН  
БЭЛГЭ ТЭМДГИЙН ЗАГВАР

1. Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн бэлгэ тэмдгийг тодорхойлоход энэхүү загварыг мөрдөнө.

2. Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн бэлгэ тэмдэг нь дараах загвартай байна. Үүнд:



2.1. Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн (цаашид "хүрээлэн" гэх) -гийн бэлгэ тэмдэг нь тус хүрээлэнгийн үйл ажиллагааны онцлог, үндсэн чиглэлийг илтгэн харуулах ба эх орныхоо тусгаар тогтнолыг сахин хамгаалах, Монгол Улсын шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлсэд хүчин зүтгэж, ажил үйлс нь өөдлөн дэвжиж, өнө мөнхөд оршин байхыг илэрхийлсэн болно.

2.2. Уг бэлгэ тэмдэг нь бүхэлдээ монгол орд өргөөний хэлбэртэй байгаа нь тус байгууллага өөрийн өвөрмөц онцлог бүхий судалгаа шинжилгээний ажил эрхэлдэг, боловсон хүчин, материаллаг баазын хувьд бэхэжсэн, Монгол Улсын шинжлэх ухааны салбарт зохих байр суурь эзэлж, хувь нэмрээ оруулж байгаа бие даасан цэргийн эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болохыг харуулна.

2.3. Бэлгэ тэмдгийн ерөнхий бүтэц нь оройдоо монгол цэргийн Хар сүлдийг мандуулан залж, түүний доор ном, нум сумыг давхарлан дүрсэлж, гол хэсэгт үзэгний хошууг байрлуулж, түүний хоёр хажуугаар "Батлан хамгаалах" (зүүн гар талд), "Эрдэм шинжилгээний хүрээлэн" (баруун гар талд) гэсэн үгийг монгол бичгийн эвхмэл үсгээр товчлон бичсэн байна.

2.3. Бэлгэ тэмдгийн манлайд залагдсан Хар сүлд нь Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнг эх орноо батлан хамгаалах эрхэм үүрэгтэй цэргийн байгууллага болохыг, голд байрлуулсан үзэг нь эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болохыг илтгэнэ.


2.4. Давхарлан дүрсэлсэн ном болон нум сум нь хүрээлэнгийн судалгаа шинжилгээний ажлын үр дүн цэргийн хэрэгт шууд нэвтэрч, Монгол Улсын батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэхэд чиглэж буйг илэрхийлнэ.

2.5. Хар сүлдний бүч бүслүүрийн уулзвар дээрх толийг нар, сарны байдалтай дүрсэлсэн нь хүрээлэнгийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил үргэлжид өөдлөн дэвжиж байхыг билэгшээнэ.


2.6. Хар сүлдний өнгө нь хар, гадуур хүрээ болон бүч, бүслүүр нь шар, бүс, бүслүүрийн уулзвар дээрх нарны өнгө нь улаан, сарны өнгө нь шар байна. Ном, нум хоёрын өнгө нь цэнхэр, сум буюу үзэгний өнгө нь шар арын дэвсгэр нь цэнхэр, хүрээ нь шар өнгөтэй байна. Эвхмэл үсгийн өнгө нь улаан байх бөгөөд доод суурь нь цэнхэр байна.

3. Хүрээлэнгийн бэлгэ тэмдгийн үндсэн өнгө ба хэмжээг зурагт үзүүлсэн байдал.


Бэлгэ тэмдгийн үндсэн хэмжээ



Бэлгэ тэмдгийн үндсэн өнгө



Хэвлэмэл хуудсан дээрх бэлгэ тэмдгийн өнгө



БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

Батлан хамгаалахын сайдын 2024 оны  
13 дугаар сарын 14 ны өдрийн  
13 дугаар тушаалын хоёрдугаар хэсрэлт

## БАТЛАН ХАМГААЛАХЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн (цаашид “хүрээлэн” гэх)-гийн бэлгэ тэмдгийг дүрслэх, хэрэглэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Бэлгэ тэмдэг нь хүрээлэнгийн чиг үүрэг, сүр хүчийг илэрхийлнэ.

Хоёр. Бэлгэ тэмдгийг дүрслэх

2.1. Хүрээлэнгийн бэлгэ тэмдгийг зураглал, оёдол, төмөр, хатгамал, хэвлэмэл байдлаар дүрсэлж болно.

2.2. Бэлгэ тэмдгийг дүрслэхдээ түүний хэмжээнээс үл хамааран баталсан эх загварын хэмжээ болон тодорхойлолтод заасан өнгийг чанд баримтална.


Гурав. Бэлгэ тэмдгийг хэрэглэх

3.1. Бэлгэ тэмдгийг монгол, англи хэл дээр хэвлэж ашиглана.

3.2. Хүрээлэнгийн бэлгэ тэмдгийг хэвлэмэл хуудас, урилга, мэндчилгээ, танилцуулга, ном, гарын авлага, зурагт хуудас, нэрийн хуудас, үнэмлэх, цахим хуудас, хүрээлэнгийн үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл бүхий материал, нийтлэл, тайлан, эмхэтгэл, судалгааны материал болон бусад бэлэг дурсгалын зүйл дээр хэвлэж хэрэглэнэ.

3.3. “Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм”-ийн 4.4.4-д , 4.4.6, “Цэргийн албыг зохион байгуулах заавар”-ын 2.16, 4.6.10-д заасны дагуу бэлгэ тэмдгийг хэрэглэнэ.


3.4. Хүрээлэнгийн төмөр ялгах тэмдгийг дараах загварын дагуу дүрсэлж хэрэглэнэ.



3.5. Хүрээлэнгийн хатгамал ялгах тэмдгийг дараах загварын дагуу дүрсэлж хэрэглэнэ.

Албаны хувцасны ялгах тэмдэг

Хээрийн хувцасны ялгах тэмдэг



Хөх Blue	
Cyan	100
Magenta	080
Yellow	000
Black	000
Red	41
Green	87
Blue	164

Шар Yellow	
Cyan	000
Magenta	000
Yellow	100
Black	000
Red	255
Green	242
Blue	18

Cyan	037
Magenta	071
Yellow	100
Black	040
Red	120
Green	74
Blue	38

Cyan	051
Magenta	062
Yellow	099
Black	054
Red	88
Green	71
Blue	43

3.6. Хүрээлэнгийн техник, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл дээр бэлгэ тэмдгийг хэрэглэж болно.

Дөрөв. Бусад

4.1. Бэлгэ тэмдгийг өөр зорилгоор хэрэглэх, дуурайлган үйлдэх, гутаан доромжлох, эх загварыг санаатайгаар гуйвуулан өөрчлөх, дүрслэхийг хориглоно.

4.2. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ